

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Булган аймгийн Соёл, урлагийн газар

2024 оны X сар

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Дээд шатны байгууллын үнэлгээ	Үнэлгээний тайлбар
ЗГ-ын тогтоол							
1	1	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр	Байгууллагын гадна хаяг болон өрөө танхимын хаягийг хос бичгээр бичиж байрлуулсан. Албан хаагчдын үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэхэд анхаарч 7 хоног бүрийн нэг өдөр үндэсний бичгийн хичээлийг аймгийн Насан туршийн боловсролын төвийн багш зааж байна. Мөн Удирдлагын академийн монгол бичгийн дунд шатны 40 цагийн цахим сургалтад 2 албан хаагч хамрагдсан. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	30%	30%	

			хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.				
2	2	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2022-12-28 Дугаар 2022_488	5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн хэмжээг өөрчилсөн Засгийн газрын тогтоолын дагуу шинэчлэн тогтоож батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэн ажиллаж байна. Цалинтай холбоотой өр авлага үүсээгүй. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	100%	
3	3	Журам шинэчлэн батлах тухай 2023-07-19 Дугаар 2023_278	2. Энэ журмыг хэрэгжүүлж ажиллахыг бүх шатны төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай.(1."Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх,	2025 оны Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Аймгийн Хөгжимт жүжгийн театрын барилга /600 суудал/, Хялганат тосгоны Соёлын төвийн барилга /400 суудал/ хөрөнгө оруулалтын саналыг АЗДТГ-н ХБТХОХэлтэс болон Соёлын яаманд хүргүүллээ. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 оноос хойш гэрээ байгуулан хэрэгжүүлсэн Рашаант, Хишиг-Өндөр сумын Соёлын төвийн барилгын их засварын ажлын "Өмч, ашиглалтын тэмдэглэгээ"-г	70%	70%	

			санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам)	журмын дагуу байршуулах ажлыг зохион байгуулах чиглэлийг өгч хэрэгжилтийг хангуулж байна. Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан			
4	4	Фестиваль зохион байгуулах тухай 2024-01-25 Дугаар 2024_41	3. Фестивалийг зохион байгуулахад зохих дэмжлэг туслалцаа үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.(1.“Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивалийг жил бүр зохион байгуулж байхаар тогтсугай.)	2024 оны 08 сарын 16-ны өдрөөс 18-ны өдрүүдэд Улаанбаатар хотын Налайх дүүргийн Тайж хайрханы бэлд зохион байгуулагдсан “Нүүдэлчин” дэлхийн соёлын фестивальд Булган аймгаас 5 ай савын 26 өвийн төрлийг түгээн дэлгэрүүлж үзүүлбэр, тоглолт, үзэсгэлэн, боловсролын хөтөлбөрөөр дамжуулан олон нийтэд таниулан сурталчилж оролцлоо. Анхдагчдын өргөө, Язгуур урлагийн Отгийн тоглолтын өргөө, Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн үзэсгэлэн, боловсролын хөтөлбөрийн өргөө, эд зүйлс агуулах зориулалтаар 4 гэрийг барьж тохижуулан тоглолт, үзэсгэлэн, олон талт үйл ажиллагааг зохион байгуулсан. Наадамд оролцсон Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч Сайхан сумын Д.Ариунжаргал 9.6 сая төгрөгийн орлого, Булган сумын Л.Наранзаяа 2.4 сая төгрөгийн орлого, 18.0 сая төгрөгийн захиалга, Тэшиг сумын Ж.Отгончимэг 1.5 сая төгрөгийн орлого, 2.0 сая төгрөгийн захиалга, Хутаг-Өндөр сумын Б.Булганбаатар 5.0 сая төгрөгийн орлого, 5.0 сая төгрөгийн захиалга, Орхон сумын Б.Энхзул 900.0 мянган төгрөгийн орлого, 4.0 сая төгрөгийн захиалга, Хутаг-Өндөр сумын О.Ганжигүүр 400.0 мянган төгрөгийн орлого олсноор нийт 19.8 сая төгрөгийн орлого олж, 29.0 сая төгрөгийн захиалга авч амжилттай оролцлоо. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн Хавсралт : 1 файл	100%	100%	
5	5	Морин	6.. Энэ тогтоолын хэрэгжилтийг	Бүх нийтийн Соёлын боловсролыг дээшлүүлэх	70%	70%	

		хуурын улсын чуулгыг өргөтгөх, морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2024-02-14 Дугаар 2024_59	шуурхай зохион байгуулахыг Засгийн газрын холбогдох гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт, арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг жил тутам Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгасугай. (5.“Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх талаар авах арга хэмжээ”-г хавсралт ёсоор баталсугай.)	аймгийн төлөвлөгөөнд Юнескогийн төлөөллийн болон яаралтай хамгаалах шаардлагатай соёлын биет бус өвийн төлөөллийн жагсаалтад бүртгэгдсэн өвүүдийн оршин тогтнох чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг төлөвлөн ажиллаж байна. Морин хуурыг эрхэмлэн дээдэлж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 9 байгууллага морин хуурын дугуйлан, шавь сургалт хичээллүүлж 108 хүүхэд, 21 насанд хүрэгч хамрагдаж байна. Морин хуур хөгжмийг эрхэмлэн дээдлэх, түгээн дэлгэрүүлэх ажлын төлөвлөгөөний төсөл бэлтгэн холбогдох байгууллагад танилцуулж санал авч байна. Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан			
6	6	Тогтоолын хавсралт өөрчлөн батлах тухай 2024-02-28 Дугаар 2024_82	2.. Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хойш тайлагнах/ (1.“Журам батлах тухай” Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ыг	Төрийн албан хаагчдад орон нутагт ажилласны нэмэгдлийг олгоход шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	100%	

			хавсралт ёсоор өөрчлөн баталсугай.)				
7	7	Журам батлах, журмын хавсралтад өөрчлөлт оруулах тухай 2024-02-28 Дугаар 2024_83	3.. Мөнгөн урамшуулал олгоход 2024 онд шаардагдах хөрөнгийг тухайн төрийн захиргааны байгууллагын төсвийн захирагчийн батлагдсан төсөвт багтаан, цаашид жил бүрийн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг төсвийн захирагч нар, Сангийн сайд Б.Жавхланд тус тус үүрэг болгосугай. (1.“Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг хавсралт ёсоор баталсугай.)	Журмын дагуу 1 албан хаагчид мөнгөн урамшуулал олгосон. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	100%	
ЗГ-ын хуралдааны тэмдэглэл							
8	8	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг	Соёл урлагийн газар-9, Төв номын сан-10, Музей-12, Хөгжимт жүжгийн театр-41 албан хаагч бүгд тоон гарын үсэгтэй. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	100%	

			Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.					
9	9	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааг эрчимжүүлэхийг Эрүүл мэндийн сайд С.Энхболдод, уг үйл ажиллагаанд салбарын болон төрийн бүх шатны байгууллагуудын ажилтан, албан хаагчдыг хамруулах, энэ	2023 онд 4 байгууллагын албан хаагч бүгд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан. 2024 оны эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 11 сард хамрагдахаар төлөвлөөд байна. Хэрэгжилтийн явц: Ажил огт хийгдээгүй			Х.Б	Х.Б

			чиглэлд салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг уриалах ажлыг зохион байгуулж зохих арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав.				
10	10	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	10 сарын байдлаар ERP-/Төрийн байгууллагуудын дотоод үйл ажиллагааны удирдлагын нэгдсэн систем/-ээр нийт 123 /ирсэн бичиг 81, явсан бичиг 42/ албан бичиг солилцсон байна. Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	100%	
11	11	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл	XIY.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийлгэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах,	Тус байгууллагат захиалгаар хийлгэсэн судалгааны ажил байхгүй Хэрэгжилтийн явц: Ажил огт хийгдээгүй	Х.Б	Х.Б	

		2023-02-01 Дугаар 2023_6	засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;				
12	12	2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл 2023-11-08 Дугаар 2023_45	XI.1.1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй, хэрэгжээгүй зорилт, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг судалж, төлөвлөсөн хугацаа, үр дүнг тооцож, хэрэгжилтийг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав;	Хэрэгжилт хангалтгүй байгаа зорилт арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодруулан шаардагдах арга хэмжээ авахыг холбогдох хэлтэс, мэргэжилтэнд үүрэг болгон ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих Хэрэгжилтийн явц: Тодорхой ахиц гарсан	30%	30%	
ЗГ-ын албан даалгавар							
13	13	“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01	1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг	Байгууллагын Вэб сайтыг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль”-ийн 8 дугаар зүйлийн дагуу хөгжүүлж, мэдээллийг цаг тухай бүрд шинэчлэн хөтлөн ажиллаж байна. http://bu.moc.gov.mn/ Хэрэгжилтийн явц: Бүрэн хэрэгжсэн	100%	100%	

			Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.				
--	--	--	---	--	--	--	--